

214



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/110

Шивээговь сум

“Нүүдэлчин Монгол-2024” соёлын биет бус
өвийн их наадмын арга хэмжээнд оролцоход
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоол, сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/42 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Нүүдэлчин Монгол-2024” соёлын биет бус өвийн их наадмын арга хэмжээнд оролцоход 1,000,000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Тус соёлын биет бус өвийн их наадамд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3.Наадамд зарцуулагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн зардлаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

4.Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа), нярав (Б.Баярцэцэг) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

42124 272

Сумын Засаг даргын 2024 оны 08-р сарын 14-ны өдрийн 4/140 дугаар захирамжийн хавсралт



“Нүүдэлчин Монгол-2024” соёлын биет бус өвийн
их наадмын төсөв

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хонь	ш	1	300,000	300,000
2	Хэвийн боов	ш	50	3500	175,000
3	Суурь эзвэн	ш	1	25,000	25,000
4	Машины хөлс	ш	1	500,000	500,000
Нийт					1,000,000